



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 4/М

Хараат

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 35 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон Нутгийн Хөгжлийн Сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжих “Халуун усны халаалтыг шийдвэрлэх” ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга: -Ц.Ундрахбаяр (3 дугаар багийн Засаг дарга)

Гишүүд: -Б.Алдармаа (Соёлын төвийн дарга)

-Д.Номин-Эрдэнэ (Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч)


Хөндлөнгийн гишүүн: -Х.Шинэбаатар (1 дүгээр багийн иргэн)

Нарийн бичгийн дарга: -Э.Баярмаа (2 дугаар багийн Засаг дарга)

2.Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хугацаанд нь зохион байгуулах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, тендер шалгаруулалтын шударга байдлыг хангаж ажиллахыг үнэлгээний хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Мөнх-Оргил)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  А.ЭРДЭНЭСАЙХАН



4823000052